



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А1102

Сангиндалай

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5 дахь заалт “Төсвийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагаан-Овоо багийн “Өвөр хад” нутаг дэвсгэрт бог малын гоц халдварт мялзан өвчний голомт үүссэн тул өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг тархаахгүй байх, пост хяналтын цэгийг стандартын дагуу байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 3,845,898 (гурван сая найман зуун дөчин таван мянга найман зуун ерэн найман мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Хорио цээрийн бүсэд хүн малын хөдөлгөөнд хяналт тавьж, хэв журам сахиулж ажиллахыг Эрэн хайх аврах салбарын дарга Онцгой байдлын ахлах дэслэгч (Б.Энхтөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

О.БАЗАРРАГЧАА



482302203